



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 08 өдөр

Дугаар A/851

Мандалговь

Тусгай зөвшөөрлийн эрх
олгох, хүчингүй болгох тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 7 дугаар зүйлийн 7.2, 7.4, 9 дүгээр зүйлийн 9.1.2, 16 дугаар зүйлийн 16.2.5, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7, 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 7 дугаар зүйлийн 7.1.7, 7.1.8, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймгийн Сайнцагаан сумын татварын албанад бүртгэлтэй Баянбулаг мандал ХХК-д архи согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрөөс 2023 оны 07 дугаар сарын 08-ны өдрийг хүртэл хугацаагаар олгосугай.

2. Өнөмөнх хайрхан ХХК-ний супермаркетын архи, согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрөөс хүчингүй болгож Мандалын.govийн хурд ХХК-ний тусгай зөвшөөрлийн эрхийг Өнөмөнх хайрхан ХХК-ний супермаркетад байрлалыг өөрчлөн шилжүүлсүгэй.

3. Баянбулаг мандал, Мандалын.govийн хурд ХХК-ний худалдааны газрын ажиллах цагийн хуваарийн хязгаарыг 08⁰⁰ -24⁰⁰ цаг хүртэлх хугацаагаар тус тус баталсугай.

4. Гарсан шийдвэрийг холбогдох газруудад хуулийн хугацаанд мэдэгдэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), тухайн аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Б.Мөнхбат), Татварын хэлтэс (М.Туяацэцэг), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Сайнцагаан сумын Засаг дарга (С.Бат-Оргил) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ



481210075